



БАТЛАВ. ТУЗ-ИЙН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ЖУРАМ

Нэг. ЗОРИЛГО

- 1.1 ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо (цаашид “Хороо” гэх)-ны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийг (1) ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах бодлого, журмыг боловсруулах (2) тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, (3) үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх чиглэлээр хяналт, удирдлагын чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.
- 1.2 Хороо нь чиг үүргийнхээ хүрээнд тодорхой асуудлаар санал, дүгнэлт гарган ТУЗ-д танилцуулах, удирдамж гаргах, хууль дүрэмд заасан зарим асуудлаар шийдвэр гаргах эрхтэй байна.

Хоёр. БҮРЭЛДЭХҮҮН

- 2.1 Хороо нь 3-аас доошгүй ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд хорооны гишүүдийн 2/3-оос доошгүй нь хараат бус ТУЗ-ийн гишүүн байна.
- 2.2 Хорооны дарга, гишүүдийг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос санал болгож, ТУЗ-ийн хурлаар, ТУЗ-ийн гишүүдийн олонхын саналаар томилно.
- 2.3 Хорооны дарга, гишүүд нь дараагийн дарга, гишүүд албан ёсоор томилогдож, ТУЗ-өөс хорооны гишүүнээс чөлөөлөх шийдвэр гартал хорооны гишүүний ажил үүргээ гүйцэтгэнэ.

Гурав. ХУРАЛ

- 3.1 Хорооны хурал нь ээлжит ба ээлжит бус байна. Ээлжит хурлыг хагас жилд нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай нөхцөлд ээлжит бус хурлыг хэдийд ч хуралдуулж болно.
- 3.2 Хуралд гишүүдийн 2/3 оролцсоноор хүчин төгөлдөр болох ба гишүүд хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд хурлыг гишүүд харилцан бие биенээ сонсож, санал бодлоо илэрхийлж болох арга хэрэгслийг ашиглан утсаар эсвэл видео хэлбэрээр зохион байгуулах эсвэл хуралд оролцоогүй гишүүний саналыг бичгээр авсан байж болно.
- 3.3 Хорооны хуралд шаардлагатай тохиолдолд компанийн удирдлагууд болон ажилтнууд, гадны зөвлөгчдийг оролцуулж болно.
- 3.4 Хорооны дарга нь хорооны хурлын тов, хурлаар хэлэлцэх асуудлыг тодорхойлох бөгөөд гишүүдийн зүгээс хэлэлцэх асуудалд оруулах саналаа хурал хуралдахаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө ирүүлж болно.
- 3.5 Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээ, материалыг урьдчилан гаргуулж, бүх гишүүд танилцсаны үндсэн дээр хэлэлцүүлэг явагдана.
- 3.6 Хороо нь хурлаар хэлэлцсэн асуудлынхаа хүрээнд дүгнэлт, зөвлөмж, удирдамж

гаргаж, холбогдох дүрэм, журмыг батална.

Дөрөв. ЧИГ ҮҮРЭГ

- 4.1 Компанийн удирдах албан тушаалд нэр дэвшүүлэх
 - 4.1.1 Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд, гүйцэтгэх захирал болон эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулахад тавигдах шаардлагыг тодорхойлж, нэр дэвшүүлэх талаар баримтлах бодлогыг тодорхойлох;
 - 4.1.2 ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнуудын ажил үүргээ гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, боловсрол, ажлын туршлага, ур чадвар, хувь хүний зан чанарын болон хараат бус байдлын шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох, тус шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
 - 4.1.3 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох үйл ажиллагааг хууль, журмын дагуу нээлттэй зарлах замаар ил тод явуулан, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг бүртгэн, урьдчилсан байдлаар үнэлж, хараат бус гишүүний хувьд компанийн тухай хуулийн 79.1-д заасны дагуу хараат бус гишүүний шаардлагыг хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гарган, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн, Хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлэх;
 - 4.1.4 Компанийн нийт хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшигчийн зүгээс Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэхээр санал оруулсан тохиолдолд компанийн тухай хуулийн 66.5-д заасан шаардлагыг хангаж байгаа байдлыг үнэлэн, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалд оруулах эсэх, нэр дэвшигчийг бүртгэх эсэх асуудлыг шийдэж, хувьцаа эзэмшигчид тайлбарыг хүргүүлэх;
 - 4.1.5 ТУЗ-ийн гишүүнийг бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө чөлөөлөх нөхцөл, журмыг боловсруулах, хэрэгжилтийг хангуулах;
 - 4.1.6 Компанийн тухай хуулийн 59.5-д заасан үндэслэлээр ТУЗ-ийн бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш гурван жилийн хугацаанд компанийн ТУЗ-ийн гишүүн байсан этгээдийн нэрийг аливаа хувьцаат компанийн ТУЗ-ийн гишүүнд дэвшүүлэхээс татгалзах;
- 4.2 Удирдах албан тушаалтнуудын ажил үүргийн тодорхойлолт, гэрээний нөхцөлийг тодорхойлох
 - 4.2.1 Компанийн гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнуудын гүйцэтгэх ажлын хүрээг нарийвчлан тогтоож, ажил үүргийн тодорхойлолтыг тэдгээр албан тушаал тус бүрийн компанийн төлөө оруулбал зохих хувь нэмэрт үндэслэн тодорхойлох;
 - 4.2.2 Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг тодорхойлох, гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах санал боловсруулах;
- 4.3 Удирдах ажилтнуудын ажлын гүйцэтгэл, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх
 - 4.3.1 Гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг тодорхойлох, гүйцэтгэлийг үнэлэх журмыг боловсруулах, журамд өөрчлөлт оруулах саналыг боловсруулах;

- 4.3.2 ТУЗ-ийн гишүүнээс бусад компанийн Эрх бүхий албан тушаалтнуудын ажлын гүйцэтгэлд Гүйцэтгэх захирлаас өгсөн үнэлгээтэй хагас жилд нэг удаа танилцаж, дүгнэлт өгөх;
- 4.3.3 ТУЗ-ийн гишүүдийн ажлыг жилээр үнэлэх, үнэлгээг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх, дахин нэр дэвшүүлэх саналыг оруулах;

4.4 Тайлагнах

- 4.4.1 Үйл ажиллагаагаа ТУЗ-д тайлагнаж, шаардлагатай асуудлыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж шийдүүлэх;
- 4.4.2 Компанийн удирдах албан тушаалд нэр дэвшүүлэх бодлого, журамд орсон өөрчлөлтийн талаар жилийн үйл ажиллагааны тайланд тайлагнах;
- 4.4.3 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах;
- 4.4.4 Компанийн ТУЗ, гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийг жил бүр хянан хэлэлцэж, ТУЗ-ийн хурал болон Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах;

4.5 Компанийн нууцыг хадгалах

- 4.5.1 Хорооны гишүүд нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан компанийн зүгээс танилцуулсан аливаа нууц болон дотоод мэдээллийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх, шууд болон шууд бус байдлаар бусдад задруулахгүй байх, гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх үүрэгтэй.

Тав. ЭРХ МЭДЭЛ

- 5.1 Компанийн хэмжээнд баримтлах Нэр дэвшүүлэх бодлогыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх талаар ТУЗ-д санал, зөвлөмж өгөх;
- 5.2 Компанийн удирдах албан тушаалуудад нэр дэвшүүлэх;
- 5.3 ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирлын үйл ажиллагааг үнэлэх, дахин нэр дэвшүүлэх, улируулан томилохтой холбогдуулан шаардлагатай тохиолдолд гаднын зөвлөх үйлчилгээ, хөндлөнгийн шинжээч, мэргэжилтнүүд, хуульчдын зөвлөгөө, туслалцааг авах, тодорхой асуудлын хүрээнд хөлсөөр ажиллуулах;
- 5.4 Шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- 5.5 Хорооны үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангуулах, шаардлагатай мэдээ, мэдээлэл, баримтыг саадгүй гаргуулах, холбогдох мэдээллийг гаргаж өгөөгүй ажилтан албан хаагчдад хариуцлага тооцох саналыг гүйцэтгэх захиралд оруулах эрхтэй.

Зургаа. ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

- 6.1 Хороо нь энэхүү дүрмийн заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТУЗ-д санал оруулж батлуулж болно.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ